



**МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ТРИНИДАД БА ТОБАГО УЛСЫН
ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ ХАМТАРСАН
АЛБАН МЭДЭЭ**

МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ТРИНИДАД БА ТОБАГО УЛС

Хоёр улс, ард түмний хооронд найрсаг харилцаа, харилцан сонирхсон салбаруудад хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн зарчим, зорилгууд болон олон улсын эрх зүй, түүний дотор аливаа улсын бүрэн тэгш эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох зарчмуудыг даган мөрдөх үүрэг амлалтаа дахин нотлон,

Дипломат харилцаа тогтоох нь хоёр орны эрх ашигт нийцэж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг цаашид бататган бэхжүүлнэ гэдэгт итгэл төгс байж,

1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн Конвенцийн заалтуудыг баримтлан, энэхүү Хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурсан өдрөөр дипломат харилцаа тогтоохоор тохиров.

Дээр дурдсаныг нотолж, хоёр орны эрх бүхий байгууллагаас зохих эрх олгогдсон дараах төлөөлөгчид энэхүү Хамтарсан албан мэдээнд Нью-Йорк хотноо 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр гарын үсэг зурав. Хамтарсан албан мэдээг монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Монгол Улсаас НҮБ-ын дэргэд
суугаа Байнгын төлөөлөгч
Воршиловын Энхболд

**БҮГД НАЙРАМДАХ ТРИНИДАД БА
ТОБАГО УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго
Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын
төлөөлөгчийн газрын Хэргийг түр
хамаарагч **Ордел Барман**



JOINT COMMUNIQUÉ
ON THE ESTABLISHMENT OF DIPLOMATIC RELATIONS
BETWEEN MONGOLIA AND THE REPUBLIC OF TRINIDAD AND TOBAGO

Mongolia and the Republic of Trinidad and Tobago,

Desirous of developing bonds of friendship and cooperation in the areas of mutual interests between their countries and people;

Reaffirm their commitment to the principles and purposes of the United Nations Charter and of international law, including the sovereign equality of States, territorial integrity and non-interference in the internal affairs of States;

Convinced that the establishment of diplomatic relations corresponds to the interest of both countries and will further strengthen international peace and security,

Have decided to establish diplomatic relations between them, in accordance with the provisions of the Vienna Convention on Diplomatic Relations of 18th April 1961, as of the date of signature of this Joint Communiqué.

In witness thereof, the undersigned representatives, duly authorized by their respective Government, have signed this Joint Communiqué in two original copies in English and Mongolian, both texts being equally authentic.

Done in New York, on 24 February 2021

**FOR THE GOVERNMENT
OF MONGOLIA**

His Excellency Mr. Enkhbold Vorshilov
Permanent Representative of Mongolia
to the United Nations

**FOR THE GOVERNMENT OF THE
REPUBLIC OF TRINIDAD AND
TOBAGO**

Mr. Ordell Barman
Chargé d'Affaires a.i.,
Permanent Mission of the Republic of
Trinidad and Tobago to the United Nations



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2013 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

Хэлэлцсэн нь: Монгол Улсаас НҮБ-ын гишүүн зарим улстай дипломат харилцаа тогтоох тухай Засгийн газрын саналыг зөвшилцөх.

Шийдвэрлэсэн нь:

1.Монгол Улсаас Антигуа Барбуда Улс, Багамын Хамтын Нөхөрлөлийн Улс, Бүгд Найрамдах Барбадос Улс, Белиз Улс, Бүгд Найрамдах Ботсвана Улс, Бүгд Найрамдах Бурунди Улс, Бүгд Найрамдах Камерун Улс, Бүгд Найрамдах Чад Улс, Бүгд Найрамдах Жибути Улс, Экваторын Бүгд Найрамдах Гвиней Улс, Эритри Улс, Бүгд Найрамдах Габон Улс, Бүгд Найрамдах Гаити Улс, Бүгд Найрамдах Кирибати Улс, Маршаллын Арлуудын Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Маврики Улс, Бүгд Найрамдах Холбооны Микронез Улс, Бүгд Найрамдах Нигер Улс, Бүгд Найрамдах Палау Улс, Бүгд Найрамдах Руанда Улс, Сент Кристофер ба Невисийн Холбооны Улс, Сент Люси Улс, Бүгд Найрамдах Сьерра Леон Улс, Бүгд Найрамдах Суринам Улс, Свазиландын Хаант Улс, Бүгд Найрамдах Того Улс, Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улс, Бүгд Найрамдах Уганда Улс, Бүгд Найрамдах Вануату Улстай тус тус дипломат харилцаа тогтоох тухай Засгийн газрын саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжиж, зөвшөөрөв.

2.Дээрх 29 улстай дипломат харилцаа тогтоох тухай албан мэдээнд гарын үсэг зурсан дарааллаар нь багцлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс гадна, дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг улс тус бүрээр боловсруулан оруулж ирэх.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

БАЙНГЫН ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ц.ЦОЛМОН

С.ДУНЖИДМАА